

Уул уурхайн салбарын татварын урамшуулал

Илтгэгч: Б.Түвшинтөгс

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн

Үндэслэл

УУХҮ-ийн яамны хүсэлтээр, энэ судалгаанд уул уурхайн салбарын татварын урамшуулал хөшүүрэгтэй холбоотой дараах асуултуудыг судаллаа:

- Олон улсад ямар төрлийн татварын урамшуулал ашиглаж байна вэ?
- Эдгээр урамшууллыг хэрэгжүүлснээр улс орнууд ямар үр дүнд хүрсэн бэ?
- Монголын уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд татварын урамшуулал шаардлагатай юу?
- Монгол Улсад татварын урамшууллыг хэрэгжүүлэх ямар боломжууд байна вэ?

Уул уурхайн салбарын татварын тойм: Уул уурхайн урамшуулал болон АМНАТ

Уул уурхайн салбарын татвар

Уул уурхайн салбар дахь татварын зорилтууд (NRGI)

- Байгалийн баялгийн нөөцөөс олох эзэн орны эдийн засгийн үр ашгийг хамгийн их байлгах
- Хөрөнгө оруулагч болон засгийн газрын хооронд эрсдэл, хүлээгдэж буй үр ашгийг эрх тэгш хуваарилах
- Үндэсний хөгжлийн үзэл баримтлал, стратегитай нийцтэй байх
- Удирдах, хэрэгжүүлэхэд хялбар байх

Уул уурхайн салбар дахь татварын арга хэрэгслүүд:

- Тогтмол төлбөр (лицензийн төлбөр, гэрээний урамшуулал) – Төслийн хэмжээ, үр ашиг, үйлдвэрлэлийн үнэ, тоо хэмжээ зэргээс үл хамааран тогтмол
- Нэгжид ногдуулах (АМНАТ, импортын тариф, НӨАТ, газрын түрээс, хөрөнгийн татвар) – бүтээгдэхүүн, үйлчилгээний урсгалд суурилдаг
- Ашгийн суурьт ногдуулах (ашгийн татвар, ноогдол ашиг, ашгийн хувь, бүтээгдэхүүн хуваах гэрээ, нөөцийн түрээсийн татвар, гэнэтийн ашгийн татвар) - бүх төрлийн зардлыг хассан орлогын тодорхой хувьд суурилдаг

Уул уурхайн урамшуулал: Олон улсын туршлага

- Орлогын татварын урамшуулал
- Орлогын татварын түр чөлөөлөлт (tax holidays)
- Суутган татварын хөнгөлөлт
- Зардалд суурилсан урамшууллууд
 - Хурдасгасан элэгдлийн арга
 - Хөрөнгө оруулалтын хөнгөлөлт (investment allowances and credits)
 - Алдагдлыг шилжүүлэх
- Импорт, экспортын татвар (эдийн засгийн онцгой бүсийн урамшууллууд)

Уул уурхайн урамшуулал: Олон улсын туршлага

- Чили:

- ААНОАТ-ын түвшин 24%
- Суутган татвар 35%
 - Хурдасгасан элэгдэл, хуримтлагдсан алдагдал
 - Хүүгийн зардлын хөнгөлөлт нь томоохон капиталыг зээлээр санхүүжүүлэх гол хөшүүрэг болдог

Перу:

- “Үйл ажиллагааны ашиг”-т суурилсан рояалти
- Уул уурхайн онцгой татвар
- Татварын тогтворжуулалтын гэрээтэй компаниудын тусгай хандив, дэмжлэг
- Төлбөр хураамж (тухайлбал: уул уурхайн бүсэд заавал төлөгдөх ёстой тогтмол төлбөрүүд)-ийг бусад төрлийн татварын сууриас хасдаг
- Уул уурхайн компани алдагдлаа 4 жил хүртэлх хугацаанд шилжүүлэх боломжтой (татвар ноогдуулах орлогын 50%-аар хязгаарлагдана)
- Уул уурхайн компаниуд орон нутгийн хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлж болох ба тус хэмжээгээрээ татварын хөнгөлөлт эдэлж болдог

Уул уурхайн урамшуулал: Олон улсын туршлага

- Австрали:

- Ашигт малтмалын түрээсийн татвар (resource rent tax) 22.5% (дунджаар)
- 2014 оны 10-р сарын 1-ээс ашигт малтмалын түрээсийн татвар цуцлагдсан
- Татвар ноогдох орлогоос хайгуулын зардлыг хасаж тооцдог
- Хайгуулын зардлыг хасалгүй тооцсон орлогын татварын алдагдлыг татварын нөхөн төлбөр эсвэл хувьцаа эзэмшигчдийн ногдол ашигт нэмэгдэл хэлбэрээр буцаан олгох хэлбэрээр нөхөх боломжтой
- Түлш шатахууны (ялангуяа, дизель түлшний) онцгой татвараас чөлөөлдөг
 - 2018 онд уул уурхайн салбарт 2,5 тэрбум австрали долларын шатахууны татварын хөнгөлөлт олгосон
 - Шатахууны OAT: шингэн түлшний литр тутамд 40.1 цент
- Байгаль орчны нөхөн сэргээлтийн зардлыг орлогын албан татвараас чөлөөлдөг

Канад:

- Татвар ноогдох орлогоос хайгуулын зардлыг хасаж тооцож болдог
- Муж бүр уул уурхайн компаниудыг шинэ хайгуулын төсөл эхлүүлэх эсвэл хайгуулаа үргэлжлүүлэхэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хайгуулыг идэвхжүүлэх тусгай хөтөлбөрүүдтэй

Уул уурхайн урамшуулал: Олон улсын туршлага


Танзани:

- Уул уурхайн тоног төхөөрөмжийг (үйлдвэрлэлийн эхний жил хүртэл) импортын татвараас чөлөөлдөг (2012)
- Шатахуунд импортын татвар ноогдуулдаггүй
- Хөрөнгийн орлогод татвар ноогдуулдаггүй
- Тусгай НӨАТ-ын хөнгөлөлт (уул уурхайн компаниуд, тэдгээрийн гэрээт туслан гүйцэтгэгчдэд нийлүүлж буй импортын болон дотоодын бараа үйлчилгээг НӨАТ-аас чөлөөлнө)
- Тусгай тэмдэгтийн хураамж 0.5% буюу харьцангуй бага (дунджаар 4% байдаг)
- Орон нутгаас ноогдуулах татварын хамгийн дээд түвшин \$200,000

Татварын системийн талаар:

- 2011 оны ОУВС-гийн тайлан: Танзани боломжит татварын орлогоос бага орлого төвлөрүүлж байна
- 2010-2015 онд алтны экспорт 500 сая ам.доллараас 1,5 тэрбум ам.доллар болж өссөн
- Алт олборлогч компаниудын татварын орлого 100 сая долларт тогтвортой байсан
 - Энэ нь АМНАТ болон цалингийн татвартай холбоотой
 - Татварын түр чөлөөлөлтийн улмаас алтны компаниуд ашгийн татвар төлөөгүй

AMHAT



АМНАТ-ЫН ТӨРЛҮҮД

Нэгжид суурилсан (тусгай АМНАТ)

- Үйлдвэрлэсэн эсвэл худалдсан бүтээгдэхүүний биет хэмжээнд ногдуулдаг
- Түүхий эдийн үнийн хэлбэлзэл болон инфляцад тохируулах зохицуулалтууд шаардлагатай
- Засгийн газар тогтмол орлого олох боломжтой
- Хяналт, удирдлагын хувьд харьцангуй хялбар, үр ашигтай
- Хөрөнгө оруулах сонирхлыг бууруулдаг- эдийн засгийн хувьд үр ашиггүй
- Ихэвчлэн үнэ цэн бага, овор хэмжээ их түүхий эдэд ашигладаг

АМНАТ-ЫН ТӨРЛҮҮД

Өртөгт суурилсан АМНАТ

- Борлуулсан уул уурхайн бүтээгдэхүүний нийт өртөгт тогтмол хувиар ногдуулдаг
- Суурийн үнэлгээг бүтээгдэхүүний олборлолтын цэгт аль болох ойр, боловсруулалт хийхээс өмнө тооцвол илүү үр ашигтай
- Практикт ихэвчлэн уурхайн амны үнээр бус борлуулалтын дүнгээр татварын суурийг тооцдог.

АМНАТ-ЫН ТӨРЛҮҮД

Ашигт суурилсан АМНАТ

- Уул уурхайн төслийн нягтлан бодох бүртгэлийн цэвэр орлого эсвэл ашигт ногдуулдаг
- АМНАТ-ын түвшнийг ихэвчлэн Засгийн газар болон уул уурхайн компани хоорондын гэрээгээр тодорхойлдог
- Эдийн засгийн хувьд илүү үр ашигтай
- Удирдлагын хувьд хүндрэл ихтэй
- Татварын суурь ашгийг тооцохтой холбоотой маргаан их үүсдэг
- Маш тодорхой, ил тод эрхзүйн орчин шаарддаг

АМНАТ-ыг тооцох нь: Олон улсын туршлага

Өмнөд Африк (Ашигт малтмал, газрын тосны нөөцийн АМНАТ-ын тухай хууль)

Боловсруулаагүй ашигт малтмал:

$$Y(u) = 0.5 + \{EBIT / \text{Gross Sales} \times 9\} \times 100$$

- $Y(u)$ - боловсруулаагүй ашигт малтмалын АМНАТ-ын хувь
- EBIT -Татварын болон хүүгийн өмнөх орлого (сөрөг байж болохгүй)
- Хамгийн бага түвшин: 0.5%
- Хамгийн их түвшин: 7%


Боловсруулсан ашигт малтмал:

$$Y(r) = 0.5 + \{EBIT / \text{Gross sale} \times 12.5\} \times 100$$

- $Y(r)$ - Боловсруулсан ашигт малтмалын r АМНАТ-ын хувь;
- EBIT- Татварын болон хүүгийн өмнөх орлого (сөрөг байж болохгүй)
- Хамгийн бага: 0.5%
- Хамгийн их: 5%

Уул уурхайн салбар дахь татварын тойм: Монгол

Монголын Засгийн газрын орлого- Уул уурхайн болон уул уурхайн бус



Эх сурвалж: Сангийн яам

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

Татвар хураамжийн нэр	Түвшин	Тэмдэглэл
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)	<ul style="list-style-type: none">Татвар ноогдуулах орлого 3 тэрбум төгрөгөөс бага бол 10%Татвар ноогдуулах орлого 3 тэрбум төгрөгөөс илүү бол 25% + 300 сая ₮	
Нэмэгдсэн өртгийн албан татвар (НӨАТ)	<ul style="list-style-type: none">Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын дүнгийн 10%	Чөлөөлөлт : <ul style="list-style-type: none">– Түүхий газрын тос– Уул уурхайн эцсийн бүтээгдэхүүн– Алтны борлуулалт

Суутган татварууд

Суутган татвар:

- Ноогдол ашиг
 - Хүү
 - Төлсөн роялти
 - Бүтээгдэхүүн, үйлчилгээний нийлүүлэлтэд төлсөн төлбөр
-
- Монгол улсын харьяатад 10%
 - Гадаадын иргэн харьяатад 20%

Чөлөөлөлт: Монгол Улсын нутаг дэвсгэрт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу түүхий газрын тос үйлдвэрлэсэн хуулийн этгээдүүдэд хуваарилсан түүхий газрын тосны борлуулалтын орлого

АМНАТ

Ашигт малтмалын төрөл	Жишиг түвшин	Нэмэгдэл түвшин
Нүүрс	<ul style="list-style-type: none"> – Дотоодын зах зээлд борлуулсан бол борлуулалтын орлогын 2.5% – Экспортод гаргасан бол 5% 	<ul style="list-style-type: none"> – Түүхий нүүрс: жишиг болгож буй зах зээлийн үнийн 25 доллароос давсан тохиолдолд нэмэлт 25 долларын үнийн өсөлт тутамд 1%, хамгийн ихдээ 5% – Баяжуулсан нүүрс: жишиг үнэ тонн тутамд 100 доллароос давбал 30 долларын үнийн өсөлт тутамд нэмэгдэл 0,5%
Монголбанк, түүнээс эрх олгосон банкинд худалдсан алт	<ul style="list-style-type: none"> – Жишиг үнээр тооцсон борлуулалтын дүнгийн 2,5%: Жишиг үнэ: Монголбанк зарласан алтны үнэ 	<ul style="list-style-type: none"> – Алтыг зөвхөн эцсийн бүтээгдэхүүн байдлаар худалдсан бол, жишиг үнэ 900 доллар/унц давбал унц тутамд үнийн өсөлтөөс хамааран 0-5% ийн нэмэгдэл АМНАТ тооцдог
Зэс	<ul style="list-style-type: none"> – Жишиг үнээр тооцсон борлуулалтын дүнгийн 5% 	<ul style="list-style-type: none"> – Хэрвээ зах зээлийн жишиг үнэ 5000 доллароос давбал зэсийн хүдрийн тонн тутамд нэмэлт 22-30%- ийн АМНАТ тооцдог (1000 долларын нэмэгдэл тутамд нэмэлт 2%-ийн) – Зэсийн баяжмалын тонн тутамд 11-15% нэмэгдэл АМНАТ тооцдог – Зэсийн эцсийн бүтээгдэхүүний хувьд тонн тутамд нэмэлт 1-5%
Бусад ашигт малтмал	<ul style="list-style-type: none"> – Борлуулалтын дүнгийн 5% 	<ul style="list-style-type: none"> – Жишиг үнэ тодорхой үнийн түвшнийг давбал 0,5% - 5%-ийн хооронд нэмэгдэл АМНАТ-г тухайн бүтээгдэхүүний тонн тутамд зах зээлийн үнээс хамааран тооцдог

Монголын уул уурхайн салбар дахь төрийн оролцоо

Уурхай	Ашигт малтмалын төрөл	Эзэмшил
Таван толгой	Нүүрс	Эрдэнэс таван толгой Таван толгой ХХК
Нарийн сухайт	Нүүрс	Монголын алт корпораци ХХК, (57%) Монгол-Хятадын Шинхуа-МАК-Нарийн сухайт ХХК, Саутгоби энерги(43%)
Багануур	Дулааны нүүрс	Төр (51%), олон нийт (49%)
Шивээ овоо	Дулааны нүүрс	Төр (14.8%), Шинэ Шивээ ХХК (85.2%)
Эрдэнэт	Зэс, молибден	Төр (51%), Монголын Зэс Корпорац (49%)
Оюу толгой	Зэс, молибден	Эрдэнэс Оюу толгой (34%) Turquoise Hill (66%) Шууд бусаар Рио Тинто эзэмшдэг

Монголын татварын хэрэгслүүд урамшуулал болж чадаж байна уу? Уул уурхайн татварууд болон ААНОАТ

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (EITI) – 2017 онд Засгийн газар 2,240.6 тэрбум төгрөгийн орлого (30.9%)

2017 онд Монголын Засгийн газрын нийт тэнцвэржүүлсэн орлого болон буцалтгүй тусламж 7,239 тэрбум төгрөг

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар

- Албан татвар ноогдуулах орлого 3 тэрбумаас бага буюу 300 сая төгрөгийн төлбөр төлөх чадваргүй бол 10%
- Албан татвар ноогдуулах орлого 3 тэрбумаас их бол 300 сая төгрөг + давсан орлогын 25%
- Уул уурхайн компаниудад зориулсан орлогын татварын тусгай систем буюу урамшуулал байхгүй

Монгол дахь татварын тогтворжуулалт

Хөрөнгө оруулалтын хэмжээ (Тэрбум төгрөг)	Тогтворжуулалтын гэрчилгээний хугацаа (жил)					Хөрөнгө оруулалтын хугацаа (жилээр)
	Улаанбаатар	Төвийн бүс	Хангайн бүс	Зүүн бүс	Баруун бүс	
30 -100	5	6	6	7	8	2
100-300	8	9	9	10	11	3
300-500	10	11	11	12	13	4
500-аас их	15	16	16	17	18	

Монголд татварын урамшуулал үйлчлэх үү?

Klemm болон бусад (2012): урамшуулал амжилттай хэрэгжих эсэх нь институцийн чанараас ихээхэн хамаардаг

Монголд институцийн чанар сул байна:

- Дэлхийн банкны “Бизнес эрхлэхүй ” индекс - 194 улсаас 74-р байрт
- Heritage Foundation “Эдийн засгийн эрх чөлөөний индекс” - 126-р байрт
- Fraser Institute “Уул уурхайн хөрөнгө оруулалтын таатай орчны индекс” - 104 улсаас 81-р байрт (2016 он)
- Fraser Institute “Бодлогын төсөөллийн индекс” - 104 улсаас 101-р байрт
- Харин эрдэс баялгийн нөөцөөр 104 орноос 50-р байранд

Монголд татварын урамшуулал үйлчлэх үү?

- Монголын татварын орчны бэрхшээл Киргиз болон бусад ижил төстэй орнуудынх шиг тийм ч ноцтой биш
- Манай улсын татварын тогтолцоонд үйлчилж буй татварын түвшин 50% - 60% (Индонез, Чили, Казахстан, Киргиз)
- Хөрөнгө оруулагчдын хувьд улс төрийн болон бодлогын тогтвортой орчин илүү чухал
- Татварын урамшуулал ашиглах боломжтой ч өнөөгийн институцийн чанарыг харгалзан үзвэл уул уурхайн салбарт урамшуулал хэрэгжүүлэх нь тийм ч ач холбогдолтой биш.

Монголд татварын урамшуулал үйлчлэх үү?

- Манай улсын хувьд татварын орчноос илүү бодлогын тогтворгүй байдал болон бизнесийн орчны хөгжил сул байгаа нь уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг сааруулах нөлөөтэй байна
- Засгийн газар бодлогоо бизнесийн орчныг сайжруулахад чиглүүлэх нь чухал ач холбогдолтой.
- Бодлогын тогтвортой байдал нэн чухал ач холбогдолтой

Анхаарал хандуулсанд баярлалаа
